1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр


“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори” төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгч

“ЗӨСҮТ” ТБАГУТҮГ	
Регистрийн дугаар	9092005
Холбоо барих утас	70282859, 88883676
Хаяг	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18131
Утас	88883676, 88092513

1.3. Төслийн байршил

“Зоонозын өвчин судлалын үндэсний төв”-ийн “Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори” төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт орших бөгөөд Чингисийн талбайгаас зүүн тийш 1,5 км-ийн зайд байрлана. Нийт 5,6 га талбайд хэрэгжинэ.



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.4. Төслийн үйл ажиллагаа

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Эрүүл мэндийн сайдын А/305 тоот тушаалын дагуу бүтцийн өөрчлөлтөд орж орчин үеийн шаардлагад нийцсэн төхөөрөмжийг шинжилгээ, оношилгоонд ашиглаж, олон улсын түвшинд чадавхажсан хүний нөөцтэйгээр 30 гаруй зоонозын халдварт өвчний оношилгоог нян судлал, ийлдэс судлал, молекул биологи, генийн дараалал тогтоох түвшинд үйл ажиллагаа явуудж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд лабораторийн оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлэх

чиглэлээр Монгол улсын засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас онцгой анхаарснаар лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг хийж, хүчин чадлыг 5 дахин нэмэгдүүлсэн байна. Биоүйлдвэрлэлийн лаборатори нь дараах лаборатори хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Нян залгиурын үйлдвэрлэлийн лаборатори
2. Химийн лаборатори
3. Тэжээлт орчин хуурайшуулалтын лаборатори
4. Тэжээлт орчин савлалтын лаборатори
5. Тэжээлт орчин үйлдвэрлэлийн хэсэг
6. Химийн бодис хадгалах өрөө
7. Тэжээлт орчин ариутгалын өрөө
8. Түүхий эд хадгалалт, бэлтгэлийн өрөө
9. Шил сав угаалгын өрөө
10. Тэжээлт орчин хадгалалтын өрөө

2026 оны байдлаар нийт 100 ажилтантай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс лабораторид 20 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Зоонозын халдварт өвчин болох тарваган тахал, боом, холер, хулгана тахал, бруцеллёз, пастереллёз, хуурмаг сүрьеэ, листериоз, гэдэсний бүлгийн нянгууд, төрөл бүрийн мөөгөнцрийн халдварт өвчний оношилгоонд ашиглагдах зориулалт бүхий 25 нэр төрлийн үндсэн, 10 төрлийн хадгалах, тээвэрлэх, 106 нэр төрлийн сонгомол, 40 нэр төрлийн ялган оношлох микробиологийн тэжээлт орчин, 201 төрлийн будаг урвалж, уусмал, нян будах грамын будгууд, 5 төрлийн будагтай цаас, 25 төрлийн нянгийн биохимийн идэвхи тодорхойлох цаас, 3 төрлийн оношилгооны бактериофаг үйлдвэрлэн лабораторийн оношилгоо шинжилгээнд ашигладаг.

Төслийн хэмжээнд жилд дунджаар 1600-1800 л оношилгооны дээрх нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн төвийн эрүүл зүй чанарын хяналтын лабораторид нян судлалын шинжилгээнд хамруулсны дараа гэрээт байгууллага болон салбар 15 ЗӨСТ-үүд, үндэсний лавлагаа лабораторийн оношилгоо, шинжилгээ, судалгааны ажилд зориулан бэлтгэн нийлүүлдэг байна.

Биоүйлдвэрлэл, ариутгал, халдваргүйжүүлэлийн албаны чиг үүрэг:

“Олон улсын эрүүл мэндийн дүрэм”, зоонозын халдварт өвчний талаарх Олон улсын болон Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөх, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан халдвар хамгааллын дэглэм болон биоаюулгүй ажиллагааны заавар журмыг баримтлах;

Зоонозын халдварт өвчний онош зүйн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх;

Зоонозын өвчин үүсгэгч бичил биетний өсгөвөр, омог (нян, вирус, эгэл биетэн), эерэгсорьц (эсрэгтөрөгч, эсрэгбие)-ыг баталгаажуулах шаардлага хангасан тэжээлт орчин, урвалжаар бүрэн хангах;

Орон нутгийн ЗӨСТ-үүдийг чанарын шаардлага хангасан хэрэглэхэд хялбар, хямд үнэ, өргөн сонголт бүхий микробиологийн тэжээлт орчин, будаг урвалжаар хангах;

Халдварт өвчний урьдчилан сэргийлэх болон дэгдэлтийн үед голомтын ариутгал халдваргүйтгэл, хог хаягдлын чиглэлээр сургалт зохион байгуулах, мэргэжилтэн бэлтгэх;



Зураг 2. Био-үйлдвэрлэлийн лабораторийн дотоод орчны зураг

1.5. Төслийн барилга, байгууламж

“Зоонозын өвчин судлалын үндэсний төв” төсөл нь нийт 5,6 га талбайд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үндсэн 1 байр, өргөтгөл 1 байр, эмнэлгийн хэрэгслийн агуулах, граж, контейнер, авто зогсоол, явган хүний зам, ногоон байгууламж зэрэг барилга, байгууламжтай.



Зураг 3. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн төв байр



Зураг 4. Өргөтгөлийн хэсэг



Зураг 5.Нөөцийн агуулах




Зураг 6. Амьтны байр



Зураг 7. Контейнер







Зураг 8.Автозогсоол болон граж

1.6. Лабораториудад ашиглагдаж буй химийн бодис

ЗӨСҮТ-ийн үндсэн үйл ажиллагаа, төслийн хүрээнд нийт 271 төрлийн химийн бодис ашиглаж байгаа бөгөөд эдгээр бодисуудыг “Грийн химистри” ХХК болон бусад химийн бодис худалдаалагч аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан худалдан авч байна.

1.7. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах тул зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, цахилгаан хангамж зэрэг дэд бүтэц сайн хөгжсөн.

Цахилгаан хангамж: Төвийн эрчим хүчний шугамаас салаалж татсан.

Дулаан хангамж: Төсөл нь жилийн 4 улирал үйл ажиллагаа явуулах бөгөөд төвийн дулаан, цахилгааны шугамд холбогдсон.

Цэвэр усны хангамж: Төвийн цэвэр, бохир ус татан зайлуулах шугамд холбогдсон.

Харилцаа холбоо: Үүрэн телефоны бүх сүлжээнд холбогдсон.

Зам харилцаа: Төслийн талбай нь төвийн хатуу хучилттай зам дагуу байрлаж байна.



Зураг 9. Төслийн талбайн зам харилцаа

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Физик газарзүй

Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн уулсын баруун өмнөд шувтрах үзүүрт Богдхан уулын ард, Туул голын өргөн хөндий ба түүний цутгал голуудаар хэрчигдсэн хэсэгт оршино. Туулын дэнж хотын зүүн хэсэгт нарийн 2.5-3.0 км орчим өргөн, баруун тийш болох тутам өргөсөн хотын баруун талд 5.0-5.5 км орчим өргөн болох ба ерөнхийдөө зүүнээсээ баруун тийшлэх тусмаа намсана. Хотын эргэн тойронд Богдхан уул, Сонгино-Хайрхан, Чингэлтэй уулс хүрээлнэ.

Төслийн талбай нь газрын гадаргын хувьд тэгш, гадаргын налуу нь 1-5.7°, өндөршил нь далайн түвшнээс дээш 1357-1370 м байрлаж байна.

2.2. Цаг уур, уур амьсгал

“Зоонозын өвчин судлалын үндэсний төв ”-ийн “Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори” төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгино-Хайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах бөгөөд төсөл хэрэгжих бүс нутгийн уур амьсгалыг бүрдүүлэгч олон хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тухайн газар орны уур амьсгалын нөхцөл бүрэлдэн тогтоно. Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг. Төсөл хэрэгжих орчмын бүс нутаг нь уур амьсгалын эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг.

2.3. Гадаргын болон гүний ус

Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотын Сонгино-Хайрхан дүүргийн 20-р хорооны нутагт орших бөгөөд усзүйн хувьд Хойд мөсөн далайн голуудын ай сав Туул голын сав газарт хамаарагдана. Төслийн талбайд хамгийн ойр орших гадаргын томоохон урсац нь төслийн талбайгаас урагш 3.4 орчим км-ийн зайд урсах Туул гол юм. Төслийн талбайд нуур, булаг шанд байхгүй. Төслийн ажилчдын унд-ахуйн хэрэгцээний усыг Ус сувгийн удирдах газартай “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ”-г байгуулан төвийн цэвэр усны нэгдсэн системээс хангаж байна.

Улаанбаатар хотын газрын доорх усны ай сав уулс хоорондын артезийн ай сав бөгөөд гадаргын болон газрын доорх усны өвөрмөц холбоог үүсгэдэг бэсрэг хэмжээтэй боловч усны харьцангуй арвин нөөцтэй. Энэхүү ай савд Хойд туйлын, Урд туйлын гэсэн 2 томоохон репюналь хагарал байдгийг геологичид зураглан тогтоосон байна. Уг ай савыг хүрээлэн байгаа уулс нь газрын доорх усны тэжээлийн бүс, Улаанбаатарын хотгор нь хуримтлал зөөгдөл, хөлийн бүс болдог.

2.4. Хөрсөн бүрхэвч

Улаанбаатар хотын Сонгино-Хайрхан дүүргийн 20-р хорооны нутагт байрлах “Зоонозын өвчин судлалын үндэсний төв ”-ийн хэрэгжүүлж буй “Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори” төслийн талбай нь Улаанбаатар хот нутаг дэвсгэр нь хөрсний газарзүйн мужлалтаар (Доржготов Д., УБ 1984, 1994) Улаанбаатар хот хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрогт багтах бөгөөд Монгол орны хөрсний ангиллаар тал газар, хөндий хотгорын хөрсний бүлэгт багтах ба судалгааны талбайд хар хүрэн хөрс тархсан байна.

2.5. Ургамлан нөмрөг

Монгол орны ургамал-газар зүйн мужлалаар Улаанбаатар хотын орчим нь Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамааруулдаг (Өлзийхутаг, 1989) боловч энэ нутаг Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрог ба Дундад Халхын хуурай хээрийн тойргийн зааг дээр оршдог учраас уулын хээр ба жинхэнэ хээрийн хэвшлийн ургамалжилтыг хосолсон шинж чанартай байна. Тухайлбал, шивээт хялгана-хазаарганат (Stipa + kryllovi + Cleistogenes squarrosa), шивээт хялгана-хазааргана-элдэв өвст хээрийн хэвшлүүд зонхилно. Зарим хотгор газраар шивээт хялгана-ширэг өлөнт (Stipa Cryllovi + Carex duriuscula), шивээт хялгана-Нангиад түнгэт хуурай хээр тохиолддог явдал Дундад Халхын тойргийн хэвшил нөлөөлснийг харуулж байна. Толгодын энгэр өврийн чулуурхаг хэсгээр шивээт хялгана-агь-шавагт (Stipa Cryllovi +Artemisia fiigada +Artemisia adamsii) болон хялгана бүхий ерхөгт (Agropyron cristatum) хэвшил бүрэлдсэн.

Төсөл нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа бөгөөд төслийн талбай орчим нь хүн амын суурьшлын бүс, хотын төв тул ойр орчмын газар талхлагдах, хүмүүнсэг ургамлын төрөл зүйл дийлэнх хэсгийг эзэлж байна. Тус төслийн талбай нь олон жилийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн газар боловч барилга байгууламж, авто зогсоол зэргээс бусад хүн, автомашины хөл хүрэхгүй газраар мод бутлаг ургамал тарималжуулсан бөгөөд төслийн талбайд хялгана хиаг алаг өвст төрлийн ургамал зонхилно.

2.6. Амьтны аймаг

“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, био үйлдвэрлэллийн лаборатори” төслийн талбай нь хүн амын суурьшлын бүс болох хотын төвд байрлах тул төсөл хэрэгжих талбай орчим амьтны аймгийн ямар нэгэн зүйл амьтан илрээгүй болно.

2.7. Нийгэм, эдийн засаг

Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотын Сонгино-Хайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт хамаарагдах бөгөөд тус бүлэгт нийгэм эдийн засгийн талаар тусгав.

Тус хороо нь 1951 онд Октябрийн районы ОСГ-ын 4 дүгээр хороо нэртэйгээр байгуулагдаж анхны даргаар Тулга ажиллаж байжээ. 1992 онд Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн дагуу зохион байгуулалтын өөрчлөлтөөр Сонгино-Хайрхан дүүргийн 20 дугаар хороо болон зохион байгуулагдсан байна. Сонгино-Хайрхан дүүргийн 1, 2, 3, 4, 18, 32-р хороо, Баянгол дүүргийн 20-р хороо, Хан-Уул дүүргийн 16-р хороотой хил залган байрладаг.

Тус хороо нь 1900 өрхийн 6863 хүн амтай, 300 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг, гэр хороолол, байшин хороолол хослосон аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн бүс юм. Тус хороонд Монгол мах экспо, Нефть бааз, Магнай Трейдийн агуулах, Буян холдинг, Улаанбаатар импекс, Монос фарм, Монос дээд сургууль, Олимд дээд сургууль, Хүнс трейд, төв цэвэрлэх байгууламж, Монгол транс, Зэвсэгт хүчны 013 дугаар анги, Зэвсэгт хүчний 150 дугаар анги, Хан богд кашмир ХХК, Мон фияа ХХК зэрэг аж ахуй нэгжүүд, Энхжин, Босса, ТНТ, Номин агуулах зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай 60 гаруй аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулдаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол сөрөг нөлөөлөл

“Зоонозын өвчин судлалын үндэсний төв”-ийн “Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори” төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв.

Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

1. **Агаар орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл:** Тус төслийн үйл ажиллагаанаас агаарын орчинд үзүүлэх гол нөлөөлөл нь ажилчид болон ойролцоох зам дагуу зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс үүсэх тоосжилт, хийн бохирдуулагч ялгарах, дуу чимээ үүсэх, хатуу хог хаягдлын задралаас агаарт бохирдуулагч бодис тархах зэрэг эх үүсвэр (үйл ажиллагаанаас)-ээс хамаарч байна
2. **Хөрсөн бүрхэвч, эдэлбэр газарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Төслийн талбай нь Улаанбаатар хот нутаг дэвсгэр нь хөрсний газарзүйн мужлалтаар (Доржготов Д., УБ 1984, 1994) Улаанбаатар хот хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрогт багтах бөгөөд Монгол орны хөрсний ангиллаар тал газар, хөндий хотгорын хөрсний бүлэгт багтах ба судалгааны талбайд хар хүрэн хөрс тархсан байна. Төслийн талбайн 7% буюу 0,4 га газар нь барилга байгууламж, автозогсоол, явган хүний зам талбайд дарагдсан бөгөөд 3.8 га газар нь ногоон байгууламж бүхий талбай, үлдсэн талбай нь сул шороон хөрстэй газар байна. Төсөл хэрэгжих үеийн хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх болзошгүй нөлөөлөл нь:

- Шатах тослох материал, ахуйн хатуу, шингэн хог хаягдлаар хөрс бохирдох болно.
- Химийн бодисын ачилт буулгалтын үеийн асгаралт
- Төслийн талбай доторх явган хүний замаас гадна жим үүсэх, зориулалтын замаас бусад замаар явах

3. **Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:** Төслөөс амьтны аймаг үзүүлэх нөлөөлөл нь машин техникийн дуу чимээнээс тухайн орчны хөрсний жижиг амьтад үргэн дайжих, орон зайн өөрчлөлт бий болох зэрэг нөлөөллүүд үүсч болзошгүй. Түүнчлэн үйл ажиллагааны явцад хатуу, шингэн хаягдлын цэг шаардлага хангаагүй, хог хаягдлыг удаах, ил задгай зориулалтын бус газарт хаях зэргээс үүдэн хөрс бохирдож, улмаар хөрсний бичил организмууд устах, газрын талхлагдлаас хөрсний хорхой шавж, бичил биетний төрөл зүйл цөөрөх магадлалтай.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д зааснаар “Зоонозын өвчин судлалын үндэсний төв”-ийн “Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори” төсөл нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННҮ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтанд хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Зоонозын өвчин судлалын үндэсний төв”-ийн “Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл “бага болон дунд” эрчимтэй боловч үйл ажиллагаанаас гарах лабораториудаас хатуу болон шингэн хаягдлыг байгаль орчинд бохирдол үүсгэхгүйгээр зайлуулах, химийн бодис болон аюултай хог хаягдалтай харилцагч ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын сургалтад хамруулах, хамгаалах хувцас хэрэгслээр хангах, химийн бодисыг хадгалах, тээвэрлэх үе шатанд анхаарч стандарт шаардлагыг дагаж мөрдөх, Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөгө нөлөөлөл, өртөгч	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал рт, аргачлал
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Усны нөөцийн хомсдол үүсэхээс сэргийлэх	Усны төлбөр төлөх		Гэрээний дагуу тоолуурын заалтаар төлбөр төлөх				1-12 сар	Усны тухай хууль Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
	Ус нэрэгчээс гарч буй хаягдал усыг нөөцийн саванд цуглуулан ногоон байгууламжийг услахад ашигладаг болох.	Төслийн хүрээнд	1 иж бүрэн		200.000		11 сар	-
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Тоосжилт, Хөрсний элэгдэл, эвдрэл Дуу чимээ	Төслийн талбайд ногоон байгууламж байгуулах, тарималжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх Эдгээр нөлөөллүүдийг зэрэг бууруулах боломжтой.	Төслийн талбайд	5600 м^2 талбайд тариалах модноос зарим хэсгийн тариалах	-	-	-	-	MNS 5916:2008 MNS 5918:2008
Нийт дүн						**200.000**		

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баритлах эрх зүйн баримт
Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох	Нийт ашиглалтын талбайд 10% буюу 5600м^2 талбайд ногоон байгууламж хийх	Улиас	Ширхэг	5	10.000	50.000	Төсөл хэрэгжих хугацаанд	- Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт - MNS5914:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт.MNS5916:2008 - Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага.
		Хайлаас	Ширхэг	5	5000	25.000		
		Шар хуайс	Ширхэг	5	5000	25.000		
		Монос	Ширхэг	5	8000	40.000		
		Нийт				**140.000**		
Шаардагдах техник, хэрэгсэл		Хүрз	Ширхэг	1	15000	15000		
		Ухуур	Ширхэг	1	20000	20000		
		Усалгааны сав	Ширхэг	1	20000	20000		
		Усны шланк	Метр	100	700	70000		
		Модны хайч	Ширхэг	1	25000	25000		
Ногоон байгууламж байгуулах зардал		Арготехникийн ажиллагаа				-	Тариалжуулалтын ажлын хугацаанд	
		Суулгацыг тээвэрлэх зардал				-		
		Ажилчдын хөлс				-		
Арчилгаа, тордолгоо	Ногоон байгууламжийн усалгаа тайралт, хэлбэржүүлэлт хийх	Төслийн талбайд				100.000	Төсөл хэрэгжих хугацаанд	
Нийт дүн 390.000								

7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Гүйцэтгэгч	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Химийн бодисын ашиглалт, хадгалалтын үе шат					
ХБ-ын хадгалалт, ашиглалтын явцад асгарах, ХХД алдагдснаар ажилласдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	ХБ-той ажиллах ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангах, 1 хүн/2 ээлж/	200.000	1-11 сар	“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл биоүйлдвэрлэлийн лаборатори”	“Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” MNS 5029:2011 MNS 6458:2014 MNS/ISO/ 13688:2000
	Химийн бодис хадгалах шүүгээг суурилуулах ажлын хөлс, бүрэн бүтэн байлгах, засвар үйлчилгээний зардал	100.000	-		
	Ажилчдад химийн бодистой харьцаж ажиллах зааварчилгаа, сургалт явуулах сургах	100.000	Ажил эхлэхийн өмнө		
	Ажлын байранд эмийн санд нөхөн хангалт хийх	100.000	-		
Ослын эрсдлээс урьдчилан сэргийлэх					
Химийн бодисын агуулахын битүүмжлэл алдагдаж, агаар, ус, хөрсөөр тархах, ХБ-ын ашиглалтын үед асгарч алдагдах	ХБ-т өртсөн үед яаралтай тусламж үзүүлэх дараалал, осолд өртсөн үед авах арга хэмжээг зургаар харуулсан самбар таниулах хуудсуудыг хийж тодорхой газарт байрлуулах	100.000	1-11 сар	“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”	“Гамшгаас хамгаалах тухай хууль” “Галын аюулаас урьдчилан сэргийлэх заавар”
ХБ-ын агуулах болон лабораторит гал гарах	Лабораторийн өрөөнүүдийн галын аюулыг хэсгийг тэмдэг тэмдэглэгээтэй болгох	100.000			
Нийт зардал		***700.000***			

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбай орчимд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллана.

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилга, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Ахуйн болон химийн аюултай хатуу хог хаягдал	Ахуйн хог хаягдал түр хадгалах савыг шинэчлэх, хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх	Үйлдвэрийн хашаанд	Улирал бүр 1 удаа	4	350.000	1.400.000	1-11 сар
	Байгаль орчинд ээлтэй хог хаягдлын менежмент сургалт авах	Төслийн хүрээнд	удаа	100.000	1	100.000	1-11 сар
	Химийн бодисын сав баглаа боодлыг аюулгүй зайлуулах, устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	Төсөл хэрэгжих бүх үе шатанд	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу төлөх. Үйл ажиллагааны зардалд тусгах			1-11 сар
	Гадаад талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Үйлдвэрийн хашаанд	ш	100.000	1	100.000	1-11 сар
Хог хаягдал хуримтлагдах	Төслийн талбай орчныг бохирдуулахаас сэргийлж, хорооны холбогдох байгууллагатай хамтран ойр орчимд тогтмол цэвэрлэгээ хийж байх	Ойр орчмын 50 метр газарт	үдаа	Зардал тусгах шаардлагагүй.			1-11 сар
Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Төсөл хэрэгжих бүх үе шатанд	Зардал тусгах шаардлагагүй.			1- 11 сар
Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдал түр хадгалах цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хатуу хог хаягдлын цэгт	Төсөл хэрэгжих бүх үе шатанд	-	-	-	1-11 сар
Нийт дүн: 1.600.000							

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтам жийн тоо	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт
1. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
1.1.	Хорт хийн агууламж: Азотын давхар исэл (NO2) Хүхэрлэг хий (SO2) Нүүрстөрөгчийн давхар исэл (CO2), дутуу исэл CO, HCN, O2.	Хөдөлгөөнт эх үүсвэрээс / Орчны хяналт шинжилгээний цэг зураг дээр нарийн харуулав/	11-р сар	1	400.000	400.000	Мэргэжлийн байгууллагаар хийлгэх	MNS 4585:2016. MNS 3384:1982. MNS 4048:1988. MNS 0017-2-5-11:1988. MNS 5013:2009. MNS 5014:2009. MNS 5002:2000.
1.2	Агаарын тоос тоосонцор ($PM_{2.5}$, PM_{10})	Бохирдол үүсэх эх үүсвэр орчимд 1 цэгээс дээж авах Хатуу хог хаягдлын цэгийн ойролцоо болон ногоон байгууламжийн ойролцоо 1 цэг	11-р сар	1	200.000	200.000	Мэргэжлийн байгууллагаар хийлгэх	
2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
2.1	Усны химийн шинжилгээ Био идэвхит нэгдлүүд Нян судлалын үзүүлэлт: Нянгийн тоо Гэдэсний бүлгийн савханцар Эмгэг төрөгч бактери Cl.perferringens	мг/дм^3 1 мл-т илрүүлэх 100 мл-т	Унд-ахуйн зориулалтаар хэрэглэгдэж буй ус	11-р сар	1	150.000	150.000	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори, Ус цаг уур орчны шинжилгээний газар	MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-2:2002: MNS 4867-1999: УСТ-3534-1983 MNS 0900:2005 MNS 4685:1998
3. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
3.1	Хөрсний физик, агрохимийн үндсэн үзүүлэлтүүд: Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO_3, P_2O_5, K_2O)	мг	Бохирдол үүсэх эх үүсвэр орчимд 1 цэгээс дээж авах Хатуу хог хаягдлын цэгийн ойролцоо болон ногоон байгууламжийн ойролцоо 1 цэг *Нийт 3 цэг*	11-р сар	1	200.000	200.000	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори, Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораториуд	MNS 3298:1991. MNS 5850:2008. MNS 3985-87. MNS 3310-91. MNS 2305-94. MNS 2305:1994.

	Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co/								
4. ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ									
4.1	Дуу шуугиан	дБА	Төслийн талбай орчимд	11-р сар	1	150.000	150.000	Мэргэжлийн байгууллагаар хийлгэх	MNS 5002:2000 MNS ISO 226:2003
Нийт дүн						**1.100.000**			

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ							
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх	Төслийн хүрээнд	1-11 сар	-	“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”	Эрх бүхий мэргэжлийн байгууллага	БОМТ-ний тайлан	Байгаль хамгаалах тухай хуулийн 10^1 Газрын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам БОНХЯ-ны сайдын 2024 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох журам Хог хаягдлын тухай хууль Байгалийн нөөц ашигласны төлбөрийн
Ажилчдын дунд байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах - Байгаль орчныг хамгаалах - Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/ - Хөдөлмөр хамгаалал - Тогтвортой хөгжлийн зорилтуудыг танилцуулах зэрэг сэдвээр	Бүх ажилчид	1-11 сар	150.000	“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”	Байгаль орчны мэргэжилтний оролцоотойгоор	Сургалтанд хамрагдсан бүртгэл тэмдэглэл	
Химийн бодисын үлдэгдлийн тайлан мэдээг БОУАӨЯ-д жил бүр хүргүүлж тайлагнаж байх	Төслийн хүрээнд	12 сар	Зардал тусгах шаардлагагүй	“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”	-	ХБ-ын үлдэгдлийн тайлан	
Хөдөлмөр хамгааллын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах зурагт хуудас	Төслийн хүрээнд	1-11 сар	60.000	“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”	-	Хөдөлмөр хамгааллын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах самбар байрлуулсан байх	
Аюултай хог хаягдал устгах гэрээ байгуулах, хог түр хадгалах байрт цугларсан хогийг тогтмол	Төслийн хүрээнд	1-11 сар	3.600.000	“Зоонозын өвчин судлалын ариутгал	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу төлөх.	-	

хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх.				халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”	Ажиллагааны зардалд тусгах		тухай хууль болон бусад
Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд	1-11 сар	Үйл ажиллагааны зардалд тусгагдана	“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”	-	Төлбөр төлсөн баримт	
Нийт дүн 3.810.000							

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

<table>
<tr><th colspan="8">Тухай жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ</th></tr>
<tr><th>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд</th><th>тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр</th><th>Мэдээллийн агуулга</th><th>Хугацааны тов</th><th>Хэлэлцүүлгээр санал авах чиглэл</th><th>Зохион байгуулах газар</th><th>Хэрэгжүүлэгч</th><th rowspan="6">БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам Олон нийтийн оролцоо хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд</th></tr>
<tr><td>Дүүргийн байгаль орчны газар</td><td>Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна.</td><td>Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан</td><td>11-р сар</td><td>Шинжээчдийн дүгнэлт</td><td>Дүүргийн байгаль орчны газар</td><td>“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”</td></tr>
<tr><td>Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч</td><td rowspan="2">Хуралд танилцуулах, уулзалт</td><td rowspan="3">БОМТ-ийн тухай жилийн тайлан, ирэх оны төлөвлөгөө</td><td>12-р сар</td><td rowspan="2">БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах</td><td>Сум, баг</td><td>“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”</td></tr>
<tr><td>Төрийн бус байгууллага олон нийт</td><td>11-р сар</td><td>Тухай үед сонгох</td><td>“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”</td></tr>
<tr><td>Төрийн захиргааны төв байгууллага</td><td>Тайлан төлөвлөгөөг цаасан хэлбэрээр</td><td>12-р сар</td><td>Хянуулах батлуулах</td><td>Улаанбаатар хот</td><td>“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори”</td></tr>
<tr><td colspan="8"></td></tr>
</table>

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцох талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	11-12 сарын дотор	-	-	“ЗӨСҮТ” ТБАГУТҮГ
БОУАӨЯ-нд	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	11-12 сарын дотор	-	-	“ЗӨСҮТ” ТБАГУТҮГ

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2026 оны зардлыг дараах хүснэгтэд харуулав.

Зардлын хэлбэр	Нийт зардал, төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	200.000
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	390.000
Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	700.000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	1.600.000
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	3.810.000
БОМТ-г хэлэлцүүлэх, тайлагнах зардал	-
Орчны хяналт шинжилгээний зардал	1.100.000
Нийт	**7.800.000**

*“Зоонозын өвчин судлалын үндэсний төв”-ТБАГУТҮГ-ийн Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори” төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **7.800.000** (долоон сая найман зуун мянга) төгрөг болж байна.*

14. ДҮГНЭЛТ

“Зоонозын өвчин судлалын үндэсний төв”-ийн “Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн лаборатори” нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлана. Төслийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулж Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланд 2026 оны нийт зардал 7.800.000 төгрөг байхаар тусгасан байна.